

The Defacto Gazette

Мэдээлнэ. Зоригжуулна. Мэдэлжүүлнэ.

АГУУЛГА ▾

МОНГОЛ, АНГЛИ ХЭЛ ДЭЭР ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН NO. 23 ПҮРЭВ, 2017.11.30 WWW.DEFACTO.MN



Гэрэл зургийг ikon.mn

Хөгжлийг чирэх хүлээлт дагуулсан уул уурхайн салбар маань одоогоор хөгөө л чирж явна. Буруутан нь мэдээж салбар нь өөрөө биш, түүний засаглал юм, Хуудас 1

НИЙТЛЭЛ

- 1 Хөгөө чирж яваа уул уурхайн салбар
- 4 Монгол Улс дахь хуульч, өмгөөлөгчийн хараат бус байдал

ЯРИЛЦЛАГА

- 3 Т.Чулуун МУИС-ийн Тогтвортой хөгжлийн хүрээлэнгийн захирал



Т.Чулуун

МУИС-ийн Тогтвортой хөгжлийн хүрээлэнгийн захирал

Нэг хүнд ногдох хүлэмжийн хийн ялгаруулалт нь хичнээн бага байх тусам тухайн улсын хүний хөгжлийн индекс нь сайн байна гэсэн үг. "Байгаль орчин" гэсэн үзүүлэлтийг нэмж оруулаад хүний хөгжлийн индексийг тооцохоор үзүүлэлтийн эхэнд байсан Америк, Австрали зэрэг орнууд нэлээн хойшоо жагсаж байгаа юм, Хуудас 3

ТОЙМ

- 6 ПАРАДАЙЗЫН БАРИМТУУД (THE PARADISE PAPERS) ДЭЛГЭГДЛЭЭ У.Хүрэлсүх МАН-ын ДАРГА БОЛЛОО
Суудлын автомашины импорт өслөө



Гэрэл зургийг eagle.mn

2017 оны эхний 10 сарын байдлаар 43 мянган суудлын автомашин импортолсон бөгөөд 223 сая долларын импорт юм. Энэ нь 2016 онтой харьцуулахад 35.5 хувийн өсөлттэй байна, Хуудас 7



Гэрэл зургийг icij.org

Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүлчид Парадайзын баримтууд гэх оффшор данснуудын тухай мэдээллээ. Нийтдээ 13.4 сая баримтууд байсан бөгөөд үүнээс 25 мянган баримтыг нь дэлгэжээ. Үүнд Монгол улстай холбоотой 16 нэр багтсан. 67 орны 382 сэтгүүлч оролцож уг баримтуудыг дэлгэсэн, Хуудас 6

INFORMING. INSPIRING. EMPOWERING.

Jargal DeFacto

DEFAC TO REVIEW (2017.11.26)

WATCH ARTICLE →

@JARGALDEFAC TO 9 HOURS

ALUMNI HIGHLIGHT - JARGAL DEFAC TO

WATCH ARTICLE →

@JARGALDEFAC TO 9 HOURS

Нүүр Хэлэлцүүлэг Хайлт Тухай Сануулга

Гар утасны аппликэйшн, Jargal Defacto

Та "Дефакто Газет" цахим сонинг тогтмол төлбөргүй хүлээн авахыг хүсвэл www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ үү.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Дамбадаржаагийн Жаргалсайхан
Дангаасүрэнгийн Энхбат

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Ерөнхий редактор: Ганбаатарын Жавзмаа
Баг: Батхүүгийн Амар
Отгонбаярын Наранцацрал
Өсөхбаярын Биндэрьяа
Адьяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ:

✉ editor1@jargaldefacto.com
☎ +976-94109342
🌐 www.defacto.mn



407

Д.Жаргалсайхан

Долоо хоног бүрийн нийтлэл, jargaldefacto.com/category/23

Хөгөө чирж яваа уул уурхайн салбар

Эдүгээ уул уурхайн салбаргүйгээр Монгол улсыг ч, эдийн засгийг нь ч төсөөлөх аргагүй болжээ. Энэ салбарт улсын экспортын орлогын 86, аж үйлдвэрийн 71, эдийн засгийн 18, төсвийн орлогын 30 хувь нь тус тус бүрдэж байна. 2014 онд Монгол улс 1.2 сая тонн зэс борлуулж 4.5 их наяд, 25 сая тонн нүүрс борлуулж 1.4 их наяд, 7.5 тонн алт борлуулж 543 тэрбум төгрөг тус тус олжээ. Энэ гурав нийлээд 6.5 их наяд төгрөг, буюу эрдсийн экспортын бараг 90 хувийг эзэлж буйг Ашигт малтмалын газраас (АМГ) мэдээлжээ.

Тэгвэл яагаад энэ их орлоготой байж монголчуудын гуравны нэг нь ядуу байгаа юм бэ? Яагаад энэ их орлоготой орны төр засаг нь ирээдүйгээ барьцаалан бонд гарган зээл авч, зээлээ зээлээр төлж, гадны улсуудаас мөнгө гуйгаад явна вэ?

Хөгжлийг чирэх хүлээлт дагуулсан уул уурхайн салбар маань одоогоор хөгөө л чирж явна. Буруутан нь мэдээж салбар нь өөрөө биш, түүний засаглал юм.

Байгалийн баялгийн засаглал

Монголын уул уурхайн засаглалыг олон улсын Байгалийн Баялгийн Засаглалын Хүрээлэнгээс (NRGI) дүгнэж 2017 онд тайлан гаргажээ. Уул уурхайн баялагтай 89 улсын засаглалыг гурван бүлэгт хувааж 100 оноогоор дүгнэхэд Монгол улс 64 оноогоор 15-р байрыг эзэлжээ. Энэ бол байгалийн баялгийнхаа үр шимийг нь хэрхэн хүртэж байгаа, орлогоо удирдах түвшин, бизнесийг дэмжих орчин гэсэн гурван хэсгийн дундаж үзүүлэлт ажээ.



[дэлгэрэнгүйг resourcegovernanceindex.com]. Байгалийн баялгийнхаа үр шимийг Монгол улс 63 хувьтай буюу дундаас дээш түвшинд хүртэж байгаа гэнэ. Засаглалын дүрэм, журам, дэг жаяг нь байгаа ч, тогтвортойгоор мөрдөж хэрэгжүүлдэггүй, үнэ цэнийг нь иргэд тэгш бус хүртдэг, хүртээх нийгмийн зардал нь их өндөр гэж биднийг дүгнэжээ. Дүгнэлтийг лиценз олгох, татвар хураах, орон нутгийн хөгжилд үзүүлэх үр нөлөө, төрийн өмчит компанийн өгөөж гэсэн дэд бүлгүүдээр задлан гаргажээ.

2014 онд байгалийн баялаг нийт экспортын бараг 90 хувь болсон учир, ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч 49 орны дотроос Монгол байгалийн баялгаасаа хамгийн их хараат улсаар тодорчээ,

Уул уурхайн хайгуулын болон олборлолтын лицензийн менежментийг 61 оноогоор дүгнэжээ. Ашигт малтмалын газар лицензийг түрүүлж өргөдөл гаргасанд нь, түрүүлж олгох зарчмаар ихэнхдээ, заримдаа тендэрээр олгож иржээ. Лиценз олгох үйл явц цахимаар ил тод болдог ч, орон нутгийн засаг захиргааны дарга нарын гарын үсэг авах хэсэг нь ихээхэн цаг хугацаа, хөрөнгө хүч шаарддаг. Хүчин төгөлдөр байгаа лицензийн мэдээллийг Кадастрын албаны цахим хуудсанд нийтэлдэг. Лицензид хийх ёстой ажлыг чанарын биш зөвхөн мөнгөн дүнгээр л илэрхийлдэг. 2014 онд 497 хувийн компани 802 зөвшөөрөлтэй талбайдаа төрийн санхүүжилтээр 62 төсөлд хайгуулын ажил хийгджээ.

Татвар хураах дүрэм журам нь харьцангуй тодорхой, тэгээд ч Үндэсний Аудитын Газар давхар хянадаг учир Монгол улс 82 буюу хамгийн өндөр оноо авчээ. Салбарын тухай дэлгэрэнгүй мэдээллийг Олборлох Үйлдвэрийн Ил Тод Байдлын Санаачилга (ОУИТБС, or EITI) -ын тайланд оруулдаг ч, заримдаа цаг алдаж, оройтуулдаг юм байна.

Монголын төрийн өмчит компаниудын [ТӨК] засаглалд 40 оноо өгснөөр Евразийн есөн улсаас долоод жагсчээ. Стратегийн ач холбогдол бүхий орд газруудын төрийн ашиг сонирхлыг удирдах

▶ зорилгоор “Эрдэнэс Монгол” компанийг 2007 онд байгуулсан. Тус компани нь монголын уул уурхайн хамгийн том, зэс алтны гэх мэт таван уурхайн хувьцааг эзэмшдэг. Гэтэл энэ компани хамтарсан үйлдвэрүүдийнхээ санхүү, үйлдвэрлэл, борлуулалттай мэдээллээ нийтэд мэдээлдэггүй ажээ. Улсын Их Хурал нь ийм мэдээ, тайланг шаарддаггүй, хянадаг ч үгүй ажээ. Мэдээлэлгүй учир компанийн үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналт ч сул байна.

Баялгийнхаа орлогыг удирдах түвшингээр 54 оноо буюу дунд авчээ. Улсын төсвийн тайлан харьцангуй ил тод байдаг ч, төсвийн тодотголыг жилд нэг хоёр удаа хийдэг болов. Энэ нь 2010 онд батлагдсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа, төсвийн өр, тэнцэл, зарлагатай холбоотой дүрмүүдээ үргэлж л өөрчлөхөд хүргэж байна. Салбар бүрийн орлого, өрийн тухай мэдээллийг түргэн шуурхай нийтэлдэг цахим хуудас байхгүй байна.

2014 онд байгалийн баялаг нийт экспортын бараг 90 хувь болсон учир, ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгч 49 орны дотроос Монгол байгалийн баялгаасаа хамгийн их хараат улсаар тодорчээ. Төсвийн орлого нь нүүрс, зэсийн үнийн өөрчлөлтөөс бараг бүтэн хамаарах болсноор эдийн засаг нь Евразидаа хамгийн төрөлжөөгүй улс болжээ.

Байгалийн баялгийн орлогоо иргэддээ бэлэн мөнгө шилжүүлэх замаар хуваарилж, зардал нь өндөр хэмээн хааяа зогсоож ирлээ. Ямар ч гэсэн орлогын хуваарилалтыг нь ил тод гэж үзээд Монголд 74 оноо өгсөн нь Бразилындараа удаалжээ. Хуваарилалтыг мөн аймаг, сумын түвшинд нөөц ашигласны болон лицензийн тодорхой хэсгийг шилжүүлэх замаар явуулж байсан ч өнөөдөр бараг зогсчээ. Байгалийн баялгийг нь олборлож байгаа сумуудад юу ч ирэхгүй болсон тухай гомдол гарах боллоо. Тод жишээ нь газрын тосыг нь олборлож буй Дорнод аймгийн Матад сум.



Гэрэл зургийг ikon.mn

Байгаль орчны яам нь уурхайн байгаль орчны нөлөөллийн үнэлгээг (БОНҮ) олон нийтэд түгээх зорилготой төвлөрсөн цахим хуудас ажиллуулдаг боловч “Эрдэнэс Монгол” (ТӨК)–ийн оролцоотой хамтарсан үйлдвэрүүдийн үнэлгээнүүд бүрэн, тодорхой нийтлэгдэхгүй байна.

Байгаль орчны яам нь уурхайн байгаль орчны нөлөөллийн үнэлгээг (БОНҮ) олон нийтэд түгээх зорилготой төвлөрсөн цахим хуудас ажиллуулдаг боловч “Эрдэнэс Монгол” (ТӨК)–ийн оролцоотой хамтарсан үйлдвэрүүдийн үнэлгээнүүд бүрэн, тодорхой нийтлэгдэхгүй байна,

2010 онд байгуулсан Төсвийн тогтворжуулалтын сангийн үйл ажиллагаанд (ТТС) 42 оноо олгосон нь тайланд орсон улсуудын 34 сангаас 18–д жагсчээ. Энэ сан жилийн тайлангаа нийтэлдэггүй, Улсын Их Хурал нь хянадаггүй, зөвхөн юу хийгдэж байгаа тухай мэдээллийг Сангийн яамнаас хааяа цахим хуудсандаа тавьж байна.

Мөн урт хугацааны хуримтлал үүсгэх зорилгоор Ирээдүйн өв санг (ИӨС) энэ жилийн эхнээс байгуулсан ч хуулийнхаа дагуу улирал, хагас жилийн тайлангаа гаргаагүй байна.

Уул уурхайн бизнесийн орчныг 73 оноогоор дүгнэжээ. Салбарын холбогдолтой тоо баримт дүрэм журам нь харьцангуй ил тод, байдаг боловч өөрчлөлт нь түргэн шуурхай нийтлэгдэхгүй байна. Засгийн газрын болон яамдын бүтэц бүрэлдэхүүн нь үргэлж солигдож, бодлого нь ч дагаж өөрчлөгддөг учир уул уурхайн бизнесийн орчин тодорхой бус, гадаадын хөрөнгө оруулахад таатай нөхцөл бүрдэж чадахгүй байна. Энэ тухай тайланд тодорхой тусгаагүй учир монголыг харьцангуй өөдрөгөөр үнэлжээ.

Монголчууд шинээр хийж бүтээсэн зүйл нь бага, дэлхийн зах зээл дээр ноолуураас өөр бүтээгдэхүүн гаргаж чадаагүй байгаа учраас эдийн засаг нь сэргэж, засаглалаасаа болоод эдийн засгийн хямралаасаа гарч чадахгүй байна.

Өнөөдөр төр засгийн хэрэгцээ, хэрэглээ нэмэгдсээр, авлигатай дорвитой тэмцэж чадахгүй байгаа учир төсвийн алдагдал нь тэлсээр, гадаадын засгийн газраас мөнгө гуйж Монгол улс амьдарч байна.



ДЕФАКТО ЯРИЛЦЛАГА

Англи, монгол хэл дээрх ярилцлага, jargaldefacto.com/category/8

Т.Чулуун
МУИС-ийн Тогтвортой хөгжлийн хүрээлэнгийн захирал

Ж: 2011 онд шинжлэх ухааны эрдэмтдийн мөрөөддөг Nature сэтгүүлд таны “Time to stop celebrating the polluters” нийтлэл гарсан. Та нийтлэлдээ хүний хөгжлийн индексийг тогтвортой хөгжлийн индексэй уялдуулах тухай санал гаргаад дэмжигдээд явж байна. Энэ тухайгаа дэлгэрэнгүй ярьж өгөөч.

Т.Чулуун: “Бохирдуулагчдыг өөгшүүлэн магтахаа зогсоох цаг болсон” гэсэн нэртэй нийтлэл хэвлэгдсэн юм аа. НҮБ-ын түвшинд улс орнуудыг 20 гаруй жил хүний хөгжлийн индексээр нь жагсааж ирсэн. Эдийн засгийн өсөлт нь хүний боловсрол, эрүүл мэндэд хэр их нөлөөтэй байна вэ гэдгийг хэмждэг индекс юм. Гэтэл үүнд зөвхөн эдийн засаг, нийгмийн үзүүлэлт л байдаг. Хэрвээ энэ индексийг тогтвортой болгоё гэвэл нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн гурван зүйл гурвуулаа байх ёстой гэсэн саналыг дэвшүүлсэн юм. Өөрөөр хэлбэл байгаль орчин гэсэн үзүүлэлтийг нэмж тооцё гэсэн саналыг гаргасан.

Нэг хүнд ногдох хүлэмжийн хийн ялгаруулалт нь хичнээн бага байх тусам тухайн улсын хүний хөгжлийн индекс нь сайн байна гэсэн үг. “Байгаль орчин” гэсэн үзүүлэлтийг нэмж оруулаад хүний хөгжлийн индексийг тооцохоор үзүүлэлтийн эхэнд байсан Америк, Австрали зэрэг орнууд нэлээн хойшоо жагсаж байгаа юм.

Ж: Хүлэмжийн хий гэдгийг уншигчдад ойлгогдохоор энгийнээр тайлбарлаад өгөөч.

Т.Чулуун: Газрын гүнд байгаа нүүрс, газрын тос, байгалийн хий зэргийг шатаахаар С нь хүчилтөрөгчтэй нэгдэж СО юмуу СО2 хэлбэрээр хүлэмжийн хий болж

ялгарч байна гэсэн үг юм. Харагдаж байгаа нь бол утаа. Энэ хүлэмжийн хий нь агаар мандалд хэт их байхаар яг хүлэмж шиг дэлхийг дулааруулах үр дагавар үзүүлдэг. Хүлэмжийн хийг хүн төрөлхтөн маш ихээр шатаадаг болсноос хойш дэлхий дулаарч, өндөр уулын мөс, цас хайлах, Антарктидын мөс хайлах гэх мэтээр далайн түвшинг нэмэгдүүлж байгаа юм. Манай оронд бол илүү хуурайшуулах, усны нөөцийг багасгах муу үр дагавартай байгаа.

Ж: Анх энэ асуудлыг АНУ анзаарч олон нийтийн анхаарлын төвд гаргаж ирэхэд түүхэндээ дэлхий дээр ийм асуудал үүсч байсан энэ нь түр зуурынх буюу арилчихдаг гэсэн мэдээллийн эсрэг урсгал явж байсан. Энэ нь шинжлэх ухааны үндэслэлтэй юу?

Т.Чулуун: Энэ бол шинжлэх ухааны үндэслэлгүй зүйл. Агаар мандал дахь нүүрстөрөгчийн давхар ислийн хэмжээ сүүлийн 800 мянган жилийн туршид 180–280 –ын хооронд хэлбэлзэж байсан бол одоо 400 болчихсон байгаа. Бид 800 мянга орчим жилд байгаагүй нөхцөлд амьдарч байгаа гэдэг нь шинжлэх ухаанаар батлагдчихсан зүйл.

Ж: Монгол улсын ногоон хөгжлийн бодлого гэж юу вэ?

Т. Чулуун: Монгол улсын онцлогт тохирсон тогтвортой хөгжлийн зорилтууд ямар байх ёстойг боловсруулах зорилгоор тогтвортой хөгжлийн бодлогыг гаргасан. Гол санаа нь бол хөгжсөн орнууд ихэвчлэн эхлээд байгаль орчноо доройтуулчихаад дараа нь засах гэж оролддог. Жишээ нь Солонгос улс ойгоо сүйрүүлээд дахин сэргээж байна, Хятад улс байгаль

орчноо сэргээх гэж маш их хөрөнгө зарж байна гэх мэтчилэн. Тогтвортой хөгжлийн бодлогын гол зорилго нь үүнийг товчлоод хөгжих боломжийг гаргах юм. Хамааралтай салбарын яамдуудтай хамтарч ажиллаад боломжтой гэсэн тодорхой хэдэн зорилтуудыг багтааснаар Монгол улс өөрийн гэсэн тогтвортой хөгжлийн зорилттой болсон байгаа.

Ж: Уул уурхай бидний хоолоо олж идэж байгаа гол салбар хэдий ч байгальдаа хэтэрхий “хэрцгий” хандах нь элбэг. Нөхөн сэргээлт хийсэн компаниуд байхад тэр чигээр нь орхичихсон компаниуд ч байна. Цөлжилт нэмэгдэж байна гэж байгаа нь бид эхлээд байгалиа устгачихаад буцааж босгох ажилдаа орчихсон явж байгаа юм биш үү?

Т.Чулуун: Бид сүйрэл рүүгээ хэтэрхий гүн орох юм бол гарч чадахгүй болох хувилбар бий. Тийм учраас сүйрэл рүү орохгүй байх санааг гаргаж ирэх хэрэгтэй байгаа юм.

Ж: Энэ бодлогын гол цөм нь юу юм бэ? Бид яаж хөгжүүлэх вэ?

Т.Чулуун: Эрэмбээрээ эхлээд хүн, байгаль, сэргээгдэх нөөц болон үл сэргээгдэх нөөц гэдэг бол бид уул уурхайгаа цөмөө гэж авч үзээд байдаг. Өөрөөр хэлбэл цөөхөн хүн амтай учраас оюуны нөөцөд тулгуурлах, ДНБ-ийхээ 2 хувийг шинжлэх ухаан технологи, инновацид зарцуулдаг болох, экосистемээ хамгаалж байгалийн нөөцийг нөхөн сэргээх, сэргээгдэх эрчим хүчийг 2020 он гэхэд 20 хувь, 2030 онд 30 хувьд хүргэх гэсэн санаануудыг голлож дэвшүүлсэн.

Ж: Манайх шиг нэг хүнд ногдох энергийн хэмжээ багатай оронд сэргээгдэх эрчим хүчний хэмжээг тэгж ихэсгэнэ гэхээр дэндүү том зорилт биш үү?

Т.Чулуун: Эрчим хүчний яамны зорилготой холбоо хамааралтай зорилгуудыг сонгож авсан байгаа. Үүнийг хэтэрхий том зорилго гэж огт үзэхгүй байна. Энэ бол хөгжлийн хандлага болчихоод байгаа зүйл. Аливаа хөгжил энергийн урсгал дээр суурилсан байдаг учраас бид эрчим хүчний асуудлыг дээгүүр тавьдаг.

2017.10.18

Ярилцлагын бүрэн хэийг <http://jargaldefacto.com/article/t-chuluun-chuluun-togtokh> холбоосоор үзнэ үү.

ALL-NEW DISCOVERY

www.landrover.mn



Вагнер Ази Автомотив ХХК
Нарны зам 55/1, Тээвэрчид гудамж, Сүхбаатар дүүрэг, Монгол улс, 14253
Холбоо барих: 70113673, 99106507, 99118375, 99118301

WAGNER
ASIA AUTOMOTIVE LLC



Дэлгэрийн Уянга
Өмгөөлөгч, хууль зүйн
доктор

Монгол Улс дахь хуульч, өмгөөлөгчийн хараат бус байдал

“Хуульчдын гүйцэтгэх үүрэг Хоролцооны тухай НҮБ-ын Суурь зарчмууд”-д “Хүн бүр эдлэх ёстой хүний эрх, суурь эрх чөлөөг хангалттай хэмжээнд хамгаалахын тулд хүн бүр хараат бус хуулийн мэргэжилтнээс үзүүлэх хууль зүйн үйлчилгээг авах боломжтой байх ёстой.” гэж заажээ. Иймээс хуульч, өмгөөлөгчийн хараат бус байдал нь зөвхөн хуульчдад өөрсдөд нь чухал бус харин хүн бүрт хамаатай асуудал юм. Энэхүү нийтлэлээр Монгол Улс яагаад хуульч, өмгөөлөгчийн хараат бус байдлыг хангах тогтолцоогүй болохыг тайлбарлая.

Түүхийг эргэн санахуй:

Социализмын үеийн “Өмгөөлөгчдийн коллеги”

Бүгд Найрамдах Монгол Улсад эдийн засгийг төвлөрүүлэн төлөвлөж, захирч, хянаж байв. Энэ тогтолцоонд иргэд чөлөөтэй өмч эзэмшиж, бизнес эрхэлж, нэгдэл холбоо байгуулах эрхгүй байсан бөгөөд үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хүчтэй хязгаарлаж байлаа.

Иргэд чөлөөтэй бизнес эрхэлбэл улсын нэгдсэн төлөвлөгөөний эдийн засагтай хувийн салбар өрсөлдөх хэмжээнд хүрч, улмаар үр ашиг, чанар муутай улсын үйлдвэрийн барааг борлуулах боломжгүй болох гэх мэтээр ерөөс социалист эдийн засгийн тогтолцоо орших боломжгүй болох байв. Социализмыг цорын ганц зам гэдэгт итгэх иргэдийн итгэлийг хадгалахын тулд үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хүчтэй хязгаарлах зайлшгүй шаардлагатай байжээ.

Социализмын үеийн “Өмгөөлөгчдийн коллеги” нь төрийн хяналтад байх мэргэжлийн холбоо байсан. Үүнийг тухайн үед байсан цорын ганц “хуулийн фирм” гэж өнөөдрийн өнцгөөс тодорхойлж болно. Коллегийг санхүү, менежментийн

хувьд “социалист аж ахуйн тооцооны зарчмын” дагуу удирдаж байв. Өмгөөлөгчдийн үйлчилгээний хөлсийг төрөөс тогтоодог байв. 1978 оны Монголын Өмгөөлөгчдийн Коллегийн дүрэм гэх мэт 1994 он хүртэл үйлчилж байсан БНМАУ-ын хууль, зарлигуудын дагуу өмгөөлөгчид нь хараат бус, чөлөөт мэргэжилтнүүд байсангүй. Тэд Өмгөөлөгчдийн коллегид хөдөлмөр эрхлэгчид байсан төдийгүй Коллегид бүтэн цагаар ажиллах үүрэгтэй байжээ. Энэхүү ажилтан-өмгөөлөгчийн зарчим зөвхөн багшлах, эрдэм шинжилгээний ажлын хувьд л үйлчлэхгүй байсан тул хууль зүйн багш, эрдэм шинжилгээний ажилчид үндсэн ажлынхаа хажуугаар өмгөөлөх эрхтэй байх боломжтой байлаа.

Энэхүү төрийн өмчийн “хуулийн фирм”, тус фирмд бүтэн цагаар ажиллах үүрэгтэй хөдөлмөрчин-өмгөөлөгчийн тогтолцоо нь өмгөөлөгчдийг төрөөс бүрэн хараат болгож байсан ба өргөн эрх мэдэлтэй “Шүүх Яам” нь Өмгөөлөгчдийн Коллегийг бүх талаар хянах эрхийг хуулийн дагуу эдэлж байжээ.

1978 оны Монголын Өмгөөлөгчдийн Коллегийн дүрэм гэх мэт 1994 он хүртэл үйлчилж байсан БНМАУ-ын хууль, зарлигуудын дагуу өмгөөлөгчид нь хараат бус, чөлөөт мэргэжилтнүүд байсангүй

Монголын Өмгөөлөгчдийн Холбоо (МӨХ)

МӨХ нь Өмгөөлөгчдийн Коллегийн дараах байгууллага юм. 1994, 2002 оны Өмгөөллийн тухай Монгол Улсын хуулиуд болон хянан шийдвэрлэх үйл ажиллагааны шинэ хуулиуд нь үйлчлүүлэгчийн эрх ашгийн төлөө тэмцэж, хүний эрхийг хамгаалах

өмгөөлөгчийн байр суурийг дээшлүүлсэн. Өмгөөлөгчид хараат бус, чөлөөт мэргэжилтэн болж, “зах зээлд орсон” юм. Өмгөөлөгчийн хөлсийг улсаас тогтоодог байсныг халж, өмгөөлөгчид нь гэрээний эрх чөлөөг эдлэх болов. Нэн ялангуяа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчид өмнөх тогтолцоотой харьцуулбал үйлчлүүлэгчээ хамгаалж чөлөөтэй үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх бодит боломжтой болсон байна. Гэвч 1994, 2002 оны хуулиуд МӨХ-ны үйл ажиллагаанд Хууль Зүйн Яам шууд нөлөөлөх боломжтой байх зохицуулалтыг агуулж байсан тул МӨХ нь Хууль Зүйн Яам болон улс төрчдийн нөлөөнөөс тусгаарлагдаагүй байжээ. Жишээ нь: 2003 онд монголын тагнуулын байгууллагын ажилтнууд Франц Улсаас Д.Энхбатыг хулгайлж монголд авчирсан хэрэгт холбогдож түүний өмгөөлөгч Г.Санжаасүрэн ил захидал бичсэн нь монголын сонин, хэвлэлээр нийтлэгдсэн байдаг. Тагнуулын байгууллагын ханд хэрхэн хулгайлагдаж, тарчлан зовсон тухайгаа телевизээр ярьж, олон нийтийн сонорт хүргэхэд нь Д.Энхбатад өмгөөлөгч Л.Санжаасүрэн тусалсан ба Л.Санжаасүрэн өөрөө 18 сараар хорих ял авсан нь олон улсын хүний эрхийн Эмнести Интернэшнл байгууллагын сонорт хүрч, тус байгууллага 2005 онд Л.Санжаасүрэнг чөлөөлүүлэх шаардлага монголын төрийн эрх бүхий албан тушаалтнуудад хүргүүлсэн байдаг. Л.Санжаасүрэн нь олон нийтэд хандсан ил захидалдаа өмгөөлөгчийн эрхийг нь МӨХ-ны саналаар Хууль Зүй Дотоод Хэргийн Яам хассан тухай заасан байдаг. Түүний өмгөөлөх эрхийг арван жилийн дараа буюу 2013 онд Ардчилсан Намаас томилогдсон Хууль зүйн сайд Х.Тэмүүжин сэргээсэн байна. Х.Тэмүүжингийн удирдлага доор хууль зүйн салбарт 2012–2014 онд эрс шинэчлэл хийж, хууль зүйн үйлчилгээний зохион байгуулалт

► өөрчлөгдсөн. 2013 оны Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль гарснаар МӨХ нь хуульчдад өмгөөлөх эрх олгох онцгой эрхээ алдсан. МӨХ нь одоо сайн дурын үндсэн дээр нэгдсэн мэргэжлийн холбоо болсон.

Шүүх, прокурорын байгууллагын өмнө үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг эр зоригтойгоор хамгаалах ёстой өмгөөлөгчид маань шүүгч, прокурортойгоо хамт нэг дээвэрт орсон байна

Монголын Хуульчдын Холбоо (МХХ)

1990—ээд оноос монголын дээд боловсролын тогтолцоог хэт либералчилснаас болж хууль зүйн боловсрол олгох олон сургуулиуд бий болсон. Зах зээл багтааж шингээж чадахгүй энэ олон тооны хуульчид ямар нэг мэргэжлийн ёс зүй, сахилгын хяналтгүйгээр хууль зүйн зөвлөх, төлөөлөх үйл ажиллагааг санал болгож эхэлсэн. Энэ үед МӨХ нь нөхцөл байдалд тохирсон хэмжээнд хуульчдын асуудлыг шийдвэрлэх, өмгөөлөгчийн эрх олгох асуудлуудад шинэ нөхцөл байдлын шаардлагад нийцсэн хэмжээнд хандаж чадаагүй юм. МӨХ—ны үйл ажиллагаанд нэн ялангуяа залуу хуульчид сэтгэл хангалуун бус байсан нь 2013 оны хуулиар МӨХ—ны эрх мэдлийг хасч, МХХ—г байгуулах нэг шалтгаан

болсон юм.

МХХ нь өөрийгөө англи хэлээр “Mongolian Bar Association” гэж нэрлэдэг. Гэвч МХХ нь хараат бус, чөлөөт хуулийн мэргэжилтнүүдийг (independent legal professionals) нэгтгэсэн Баарын Холбоо биш юм. Шүүгчид, прокурорууд нь шүүхэд төлөөлөх эрх бүхий хуульчид (өмгөөлөгчид) болон бусад хуульчдын (хууль зөвлөх) адилаар хуулийн дагуу Холбооны гишүүн байх ёстой байдаг. МХХ нь одоогоор 5303 гишүүнтэй (517 шүүгч, 506 прокурор, 2077 өмгөөлөгч, 2203 бусад хуульч).

2013 оны хуулийн байгууллагын шинэчлэл болон МХХ—г тус холбоотой хамт шинээр гарч ирсэн залуу үеийн хуульчид эрч хүчтэйгээр хамгаалдаг. Гэвч харамсалтай нь өнөөдөр бодит байдал ихэд төвөгтэй ажээ. Шүүх, прокурорын байгууллагын өмнө үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг эр зоригтойгоор хамгаалах ёстой өмгөөлөгчид маань шүүгч, прокурортойгоо хамт нэг дээвэрт орсон байна. Нэн ялангуяа, МХХ нь өмгөөлөгчид болон бусад хуульчдын эсрэг сахилгын арга хэмжээ авах эрхтэй бөгөөд МХХ—ны Мэргэжлийн хариуцлагын хорооны 30 гишүүний 24 нь шүүгч, прокурорууд байна. Энэ нь амьдрал дээр өмгөөлөгчдөд сахилгын хариуцлага оногдуулах эрхийг шүүгч, прокурорууд эдэлж байна гэсэн үг юм. Түүнчлэн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн өмгөөлөгчдөд холбогдох хэсэг нь хуучин социалист нийгмийн үеийнхтэй адил

Өнөөдрийн тогтолцоо нь өмгөөлөгчдийг шүүх, прокурортой “үзэлцэж” үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах боломжгүй болгож, “барьцаанд” оруулж байгаа тул өмгөөлөгчийн үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж төдий хэмжээгээр хязгаарлагдсан байна

өмгөөлөгчид бүтэн цагаар хууль зүйн нөхөрлөлдөө ажиллана гэсэн төсөөлөлтэйгээр боловсруулагдсан байна. Иймээс тус хуульд “Өмгөөлөгч багшлах, эрдэм шинжилгээний болон өмгөөллийн хуулийн этгээд, Хуульчдын холбоонд хамаарахаас бусад ажил, албан тушаалыг хавсран эрхлэхийг хориглоно.” гэж заажээ.

Өмгөөлөгч өөр ажил хавсран эрхэлж болохгүй гэдэг заалт нь үнэндээ амьдрал дээр биелэгдэх боломжгүй заалт юм. Хөдөө орон нутагт хуульчид зөвхөн өмгөөлөл хийгээд хоолоо олж иднэ гэдэг бараг боломжгүй зүйл. Хуульчид өөр байгууллагад хөдөлмөрийн гэрээт ажилтан байхын зэрэгцээ өмгөөлөх эрхээ хадгалж, хэрэгцээ гарвал шүүхэд төлөөлөх нь орон нутагт нийтлэг ажээ. Улаанбаатар болон хүн ам төвлөрсөн бусад бүсүүдэд ч зөвхөн шүүхэд төлөөлөх, хуулийн зөвлөгөө өгөх замаар амьдралаа хангалттай хэмжээнд залгуулж байгаа өмгөөлөгчтэй ч олон биш. Иймээс өнөөдрийн тогтолцоо нь өмгөөлөгчдийг шүүх, прокурортой “үзэлцэж” үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах боломжгүй болгож, “барьцаанд” оруулж байгаа тул өмгөөлөгчийн үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж төдий хэмжээгээр хязгаарлагдсан байна.

Эцэст нь дурдахад өмчлөх эрх, чөлөөтэйгээр ажил хөдөлмөр, бизнес эрхлэх эрхийг Үндсэн хуулийн түвшинд хангаж, хамгаалдаг ХБНГУ—д л гэхэд өмгөөлөгчид зарим төрлийн давхар ажил эрхлэх эрхгүй байдаг боловч монголынх шиг ингэж ерөнхийд нь шууд хааж боох замаар өмгөөлөгчийг өөрийг нь “өгөөш” болгодоггүй.



Гэрэл зургийг brookelawoffice.com



Дефакто Тойм

Ням гараг бүр, 19:00 цагаас
 VTV, Facebook Live

2017.11.26

1. Оффшортой холбоотой шинэ баримтууд дэлгэгдлээ
2. У.Хуралсүх МАН-ын дарга боллоо
3. Суудлын автомашины импорт өслөө
4. Ричард Гир Монголд кино хийнэ

ДЕФАКТО ТОЙМ

Долоо хоног бүрийн тойм, jargaldefacto.com/category/12

Ням гараг бүр VTV-ээр 19 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл: 2017.11.26-ны дугаар

ПАРАДАЙЗЫН БАРИМТУУД (THE PARADISE PAPERS) ДЭЛГЭГДЛЭЭ

Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүлчид Парадайзын баримтууд гэх оффшор данснуудын тухай мэдээллээ. Нийтдээ 13.4 сая баримтууд байсан бөгөөд үүнээс 25 мянган баримтыг нь дэлгэжээ. Үүнд Монгол улстай холбоотой 16 нэр багтсан. 67 орны 382 сэтгүүлч оролцож уг баримтуудыг дэлгэсэн.

МУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд “Оффшор бүст байршсан мөнгө, хөрөнгийг эргүүлэн татах боломж” сургалт хэлэлцүүлэг болсон. Мөн Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд дарга манай төрийн байгууллагууд оффшорт байгаа хөрөнгийг оруулж ирэх ажлыг хийж чадахгүй гэж мэдэгдсэн.

Б.Мөнхдөл: Юуны өмнө оффшор гэдэг үгийн утга, ойлголтыг улс төрчид зөв ярих нь чухал юм. Оффшор гэхээр бүх л зүйл муу гээд, түүнийгээ ч улс төрийн зорилгод ашиглаад байгаа нь буруу. Оффшор гэдэг үгийн утгын хувьд тухайн улсаас гадуур байгаа зүйлийг л хэлээд байгаа юм л даа. Монгол улсаас гадуур бүртгэлтэй компани дээрх зарчмаар бол оффшор болж таарна. Гэвч олон нийт, дэлхий дахинд оффшор гэдэг нь татвар багатай улс орнуудыг хэлдэг гэж ойлгох болжээ. Энэ бүст толгой компаниа байршуулбал толгой компанийн хэмжээнд бага татвар төлдөг учраас дэлхийн ихэнх компаниуд оффшор гэж хэлэгдэх бүст толгой компаниа байршуулдаг юм. Бидний мэдэх бүх томоохон компаниуд энэхүү аргыг

ашигладаг.

Ингээд хамгийн түрүүнд ойлгох хэрэгтэй зүйл бол оффшор бүст компаниа байршуулах нь хууль бус биш. Мэдээж ямар ч компани зардлаа бууруулж, татвараа бага байлгахыг эрмэлздэг тул бизнесийн зорилгоор зөв ашиглахыг нь улс төрчид ялгаж салгаж ярих нь зүйтэй. Үүнийг зөв яриагүйгээс болоод олон нийт гадаад компанийн хувьцаа худалдаж авах л юм бол хууль бус, буруу буюу хөрөнгөө нууж байна гэж ойлгох болсон байна. Хоёрдугаарт татвараас маш ихээр зайлсхийж байна гэдэг утгаар олон улсад асуудал үүсгэж байна. Английн хатан хааны хувийн хөрөнгийг удирддаг компани хүртэл хөрөнгийг нь оффшорт бүртгэлтэй компанийн хувьцаанд оруулчихсан байх жишээтэй. Энэ нь ч бас Парадайзын баримт бичгүүдэд гарч ирж байсан. Үүнээс гадна Канадын Ерөнхий сайд хүртэл үүнд холбогдсон байгаа. Харин монголоос хэд хэдэн бизнесменүүдийн нэр дурдагдсан. Татвараас зайлсхийх зорилгоор ингэж гадна компани байгуулсан байна уу? эсвэл зардлаа бууруулах буюу Монгол дахь татвараа төлсний дараах зардлаа бууруулах гээд байна уу? гэдгийг төр шалгах ёстой юм. Нэр дурдагдсан хүмүүсээс нэрлэвэл Ерөнхий сайд асан Сү.Батболдын хүү Баттүшиг ба түүний компаниудад Алтай Холдинг ХХК, И-март, Скайтел зэрэг орох бөгөөд эдгээр компанийн толгой компанийг магадгүй гадаадад байршуулсан байх. Мөн Петровис ХХК-ийн Ж.Оюунгэрэл захирал дурдагдсан ба энэ хүний төлөх ёстой татвараа төлж байна уу гэдгийг л



Гэрэл зургийг icij.org

шалгах хэрэгтэй болохоос оффшор бүст компани эзэмшихийг нь буруушаах ёсгүй юм.

Өнгөрсөн жил оффшорын тухай хууль баталсан ба үүнд төрийн өндөр албан тушаал хашдаг хүмүүс болон түүний гэр бүл, ойрын хамтрагчид нь оффшор бүст хөрөнгө байршуулахыг хориглосон байгаа. Тиймээс их хурлын гишүүний төрсөн хүү нь гадаад буюу оффшор бүст компани эзэмшиж байгаа нь нэг талаар шалгах асуудал мөн ч яг одоо энэхүү компанийг эзэмшиж байгаа эсэхийг нь л шалгах ёстой юм. Өмнөх Панамийн баримт бичгүүд нэлээд хуучны мэдээлэл буюу компаниудын нэрийг дурдсан байснаас үүдэн нэр холбогдсон хүмүүс тэдгээр компанийг аль хэдийн хаасан, одоо байхгүй гэсэн тайлбар өгч байсан.

Монгол улсын Ерөнхийлөгч оффшорын эсрэг байр суурьтай байгаа нь цэвэр популизм гэж харж байна. Дээр дурдсанчлан оффшор гэдгийг бүхлээр нь буруу, оффшор нь Монгол улсын баялагийг нуун дарагдуулж, татварыг бууруулж байна гэсэн агуулгаар оффшорыг яриад байгаа болохоос биш зөв буруу талаас нь ердөөс ярихгүй байгаа. Тиймээс Ерөнхийлөгчийн тамгын газраас хийж байгаа энэ бүхэн цэвэр улс төр юм. Мэдээж өндөр албан тушаалтай хүмүүс хуулиараа хөрөнгө орлогоо мэдэгдэх ба оффшор бүст бүртгэлтэй компани эзэмшдэг бол мөн л мэдэгдэх ёстой. Учир нь монголд үйл ажиллагаа явуулдаг олон компаниуд гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй байдаг. Ингэж бүртгүүлэхийн тулд гадны биржүүд хүлээн зөвшөөрдөггүй тул монгол компани байж болохгүй, харин заавал гадаад улсад толгой компани нь байж, тэр нь хөрөнгийн биржид бүртгэлтэй болж болдог. Жишээлбэл



NEW NISSAN PATROL

ЛИЗИНГИЙН НӨХЦӨЛ:

Урьдчилгаа **0%**

Хүү **1.4%**

Хугацаа **84**сар

УРАМШУУЛАЛ:



Хамгаалалтын хууль



Салбар сэрвэгийн эрх



4ш Өвлийн дугуй



Саломны шийтэй хамгаалалт

ҮНЭ: ₮214.0 сая

☎ 9911-0014, 9911-5140, 9910-0167

Оюу толгой ХХК байна. Гэвч Оюу толгой ХХК-ийн толгой компани нь Канадад бүртгэлтэй, Оюу толгойг эзэмшдэг дундын дамжлагууд нь оффшор бүсүүдээр дамждаг тул нэлээд шүүмжлэл дагуулдаг. Учир нь Оюу толгой ХХК монголын баялагийг гаргаж байгаа учраас монголдоо л зохих татвараа төлөх ёстой ба үүнийг нь хуулийн байгууллага, төр шалгах ёстой бөгөөд монголоос гараад бий болж байгаа асуудалд санаа зовох ямар ч шаардлагагүй. Жишээлбэл хуулиар бол Оюу Толгой ХХК-ийн Туркойз Хилл хэмээх толгой компанийн хувьцааг улс төрч хүн эзэмшиж болохгүй, Монголиан Майнинг Корпорацийн буюу Энержи Ресурсын толгой компани мөн л оффшор бүст бүртгэлтэй бөгөөд үүний ч хувьцааг эзэмшиж болохгүй болж байгаа юм. Ийнхүү нийтэд нь хориглосон нь өнгөрсөн жилийн батлагдсан хуулийн гол алдаа ба мэдээж улс төрийн шалтгаанаар үүнийг баталсан. Энэ тухай маш олон баримтууд байгаа ч зөвхөн өнгөцхөн хэсгийг л гаргасан байгаа.

Панама пейпэрс (The Panama Papers) ба Парадайз пейпэрсийн (The Paradise Papers) ялгаа нь Панама нь тухайн улсад ажилладаг нэг хуулийн фирмээс задарсан баримтууд бол Парадайз нь Карибын арлууд, British Virgin Islands, Cayman, Бермуд гэх мэт аялал жуулчлалын газруудад бүртгэлтэй нэлээд олон компаниудаас алдагдсан мэдээлэл байгаагаараа л ялгаатай юм.

У.ХҮРЭЛСҮХ МАН-ЫН ДАРГА БОЛЛОО

МАН-ын 28-р их хурал хоёр өдөр хуралдсан. Уг хурлаар намынхаа дүрмийг шинэчилсэн. МАН-ын даргад хоёр хүн өрсөлдсөн бөгөөд 63.1 хувийн саналаар У.Хүрэлсүх намын дарга болсон. Мөн намынхаа зарим албан тушаалтнуудыг томилсон. У.Хүрэлсүх дарга намынхаа УЗ-ийн гишүүдийг солино мөн энэ цагаас хойш 33, 32-ын бүлэг гэж байхгүйг мэдэгдсэн.

Б.Мөнхдөл: Мэдээж Ерөнхий сайд нь намын дарга болох нь улс төрийн тогтвортой байдалд эерэг нөлөөтэй ч огт 32,33-ын бүлэглэл байхгүй болоогүй юм. 2020 оны сонгууль хүртэл Засгийн газар маань ядаж тогтвортой байхад эерэг нөлөөтэй. 32-ын буюу ялагдсан бүлгийн зүгээс

“Хэрэв амлалтаасаа ухарсан үйлдэл хийвэл 2020 оноос өмнө 29 дэх их хурлаа хийж болно шүү дээ” гэсэн мэдэгдэл хийсэн. Энэ нь мэдээж анхааруулга өгч байгаа хэлбэр. Засгийн газраа бүх бүлгээс бүрдүүлсэн тул У.Хүрэлсүх Ерөнхий сайдад кабинетээ цаашид удирдахад хүндрэлтэй байх буюу заавал нөгөө бүлэгтэй ярилцах шаардлага гарч эхэлнэ.

Нам бүрэн эвлэрээд, нэг цул болоогүй ч энэ бол мэдээж зөв алхам. Харин дараагийн үйлдлүүд дээрээ хэр эв нэгдэлтэй байх, 2020 он хүртэл хэр тэсвэртэй байх нь иргэн, бизнесүүд, гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд ч анхаарал татах асуудал мөнөөс мөн. Мэдээж хараахан бүх юм сайхан болоогүй байна.

Их хурлаасаа бага хурлаа сонгоод, бага хурлаасаа Ерөнхий нарийн бичгийн дарга болон удирдах зөвлөлөө сонгодог. Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Д.Амарбаясгалан улиран сонгогдсон бөгөөд нам хуваагдах үед хэний талд байгаа нь харагдаж байсан учраас У.Хүрэлсүх сайдтай гар нийлж чадах хүн гэж үзээд үлдээсэн байх. Том нам учраас удаан хугацаанд асуудал үргэлжилж, удаан хөдлөх нь ойлгомжтой ч Ерөнхий сайд нь намын дарга болсноор намын эв нэгдэл төдийгүй Монгол улсын тогтвортой байдалд сайнаар нөлөөлнө. Гагцхүү энэ нам үлдсэн гурван жилийн хугацаанд амлалтаа хэр биелүүлэх нь асуудал болж байна.

МАН-ыг илүү ардчилсан боллоо гэж олон нийтийн хэрэгслээр ярьж байгаа буюу намын үүрүүдээс их, бага хурлын гишүүдээ томилох нь илүү гэж үзэж байх шиг байна. Ардчилсан нам өнгөрсөн жил намын дотоод сонгуулиа хийсэн ба нэлээд шүүмжлэл дагуулсан буюу намын гишүүд намын батламжаа авч чадахгүй байсан, буруу мэдээлэл тараасан зэргээр олон гишүүд нь саналд оролцож чадаагүй юм билээ. Үүнээс гадна маш өндөр дэнчин буюу хураамж авсан, төрийн



Гэрэл зургийг eagle.mn

эрх мэдэл авахад мөнгөөр үнэлдэг болсон нь нэгэнт нууц биш болчихсон тул түүнийгээ ч хүлээн зөвшөөрөөд дотооддоо хийж байгаа нь нэг ахиц.

СУУДЛЫН АВТОМАШИНЫ ИМПОРТ ӨСЛӨӨ

2017 оны эхний 10 сарын байдлаар 43 мянган суудлын автомашин импортолсон бөгөөд 223 сая долларын импорт юм. Энэ нь 2016 онтой харьцуулахад 35.5 хувийн өсөлт. Суудлын автомашины импортын 90 хувь нь Японоос орж иржээ. Бусад орнуудаас оруулж ирэх нь аажмаар багассаар байна.

Б.Мөнхдөл: Үүнд хоёр шалтгаан байгаа. Нэгдүгээрт сүүлийн нэг жилийн хугацаанд эдийн засаг бага зэрэг өссөн, энэ хэрээр автомашины хэрэглээ нэмэгдсэн байх. Хоёрдугаарт Япон улстай байгуулсан эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд Японоос оруулж ирэх импортын барааны гаалийн татвар багассан буюу зарим тохиолдолд бүр тэглэсэн. Энэ шалтгаан хамгийн их нөлөөлсөн байх. Өнгөрсөн жилийн зунаас 0–3 жилийн насжилттай машинд гаалийн татвар тэглэсэн, дөрвөөс дээш жил бол аажим аажмаар бууруулж байгаа. Японоос голдуу 10 хүртэлх жилийн насжилттай машиныг импортлоод байх шиг байгаа юм. Хүн бүр Японоос буруу рултэй машин орж ирж байгаад шүүмжлэлтэй ханддаг ба авто тээврийн ослын дийлэнхийг буруу рултэй машин эзэлдэг. Монгол улсад бүртгэлтэй авто машины 60 орчим хувь буруу рултэй байдаг ба гүйцэд түрүүлэх зэрэгт мэдээж буруу рултэй машин сөргөөр нөлөөлж байгаа. Шүүд хориглоё гэсэн ч дундаж болон түүнээс доогуур орлоготой иргэдийн ихэнх нь буруу рултэй машин барьж байгаа юм. Хямд учраас л Японоос их хэмжээгээр машин оруулж ирж байгаа болохоос буруу рултэй учраас импортлоогүй шүү дээ. Яах аргагүй Японоос хуучин машин илүү хямд орж ирж байгаа ба чанартай гэх ойлголт их байдаг учраас импортлодог.

Тоймын бүрэн эхийг <http://jargaldefacto.com/article/defakto-toim-2sh17-11-26> холбоосоор үзнэ үү.